

СОЦИОЛОГИ БА 1848 ОНЫ ФРАНЦЫН ХУВЬСГАЛ

С.Нарантуяа
Социологийн ухааны доктор (Ph.D)

Социологийн сэтгэлгээний томоохон сэтгэгчид болох О.Конт, А. де. Токвиль, К.Марис нар 1848 оны Францын хувьсгалын мөн чанар, тууний нийгмийн учир холбогдлын тухайд авч үзэн өөрсдийн үзэл баримтлал, сургаалийн онцлогийг тусгасан байдаг юм.

1848 оны Францын хувьсгалын тухай товчхон

... 1848-1851 он. - Энэ үеүдэд Франц улсад ар араасаа дагалдсан түр засгийн газрын түр засаглалууд ноёрхож байлаа. Энэхүү засаглал дотор нэг талаас Парисын удирдлага ба хүн ам хоёрын хоорондын тэмцэл, нөгөө талаас хууль тогтоох байгууллага ба нийт сонгогчдын эрхийн үндсэн дээр сонгогдсон авторитар засаглалыг тогтоохыг эрмэлзэж байсан ерөнхийлөгч хоёрын хоорондын өрсөлдөөн багтаж байсан. Өөрөөр хэлбэл, Франц улс нь 1848-1851 оны үед XIX зууны түүхийн үйл явцуудаас илүү XX зууны улс төрийн тэмцлүүдтэй ижил улс төрийн тэмцлийг туулж өнгөрүүлжээ.

Үнэн хэрэг дээрээ 1848-1851 онд фашистууд, демократууд, социалистуудын 3 талт тэмцлийг ажиглаж болохоор байсан ам ... (яг ийм тэмцлийн жишээ нь 1920-1933 онуудад Германд болж байсан).

Огюст Конт ба 1848 оны Францын хувьсгал **(Auguste Comte / 1789-1857/ France)**

... О.Конт удаан хугацаагаар Молитехникийн их сургуульд иалгагч багийн багахан цалин хөлсөөр амьдарч байв. Энэ байр сууриа алдсаны дараа тэрээр позитивистуудын төлж байсан хөлс мөнгөөр амьдрах болсон. Ганцаардмал сэтгэгч О.Конт нь хүн төрөлхтний шашныг бүтээж байсан ба нэгэн зэрэг өөрөө захирагч, аугаа тайлгач, бөө байсан юм ...

О.Конт өөрийн бүтээлүүддээ Франц ба Англи дахь улс төрийн нөхцөл байдлыг харьцуулан үзсэн байдаг. Тэрээр үзэхдээ, Англид аристократ анги нь монархийн нөлөөг багасгахын тулд хөрөнгөтөн ангитай, бүр ангийн ардтай нийлж холилдож байдаг. Харин Францын улс төрийн хувьсгал нь огт өөр бөгөөд, харин ч эсрэгээр монархи нь аристократын нөлөөг багасгахын тулд коммун ба хөрөнгөтнүүдтэй нийлж байлаа.

О.Контынхоор Англи дахь парламентын дэглэм нь аристократын ангийн ноёрхлын хэлбэр. Харин Францын хувьд парламент ба монархи хоёрыг хамт байлгахыг хүссэн нь хор хөнөөлтэй, үр дагавартай улс төрийн алдаа болно. Учир нь дэглэмийн дээд илрэл болсон монархи нь Францын хувьсгалын дайсан байсан юм. өөрөөр хэлбэл энэ монархи, парламент хоёрыг хослуулах гэсэн санаа нь зарчмын алдаан дээр суурилж байсан. Алдаа нь юу вэ гэвэл, Францын түүхийг хөндөх болно. Энэ байдал нь О.Контод боломжгүй мэт. Харин төвлөн удирдах үзэл санаа нь Францын түүхэнд хууль ёсоор тохирох мэт О.Контод санагдаж байсан. Энэ тохиолдлыг тэрээр нилээн гүнзгий орж судалсан байдаг. “Позитив философийн курс” зохиолын хэсэг нь энэ талаарх О.Контын улс төрийн ба түүхийн үзэл санааг тодорхойлдог. О.Конт үзэхдээ, түүхийн ба улс төрийн үзэл баримтлалууд нь гол төлөв социологийн байр сууринаас үүдэн гардаг байна.

О.Конт ямар байдлаар социологийг өөртөө төсөөлж байсан, Э.Дюрхейм (Emile Durkheim / 1858-1917/ France) социологийг яаж хэрэглэж байсан зэргээс харахад социологи нь улс төрийн бус, нийгмийн үзэгдлүүдийг гол болгож, бүр улс төрийн үзэгдлүүдийг өөртөө захируулж байсан.

Алексис де Токвиль ба 1848 оны Францын хувьсгал
(Alexis de Tocqueville / 1805-1859 / France)

Францын их хувьсгалын талаарх О.Конт, А.де.Токвиль нарын нийгмийн байр суурь нь тэс өөр юм.

... Алексис де Токвиль нь Францын хуучин аристократ ангиас гаралтай. 1848 оны хувьсгалын үеэр тэрээр Парист байжээ. Тухайн үеийн үйл явдлууд, өрнөл явц нь түүний сэтгэлийг маш их догдуулдаг байлаа. А.де.Токвиль 1848-1851 онуудад монархист байж байгаад энэ үзэл нурах үеэр консерватив үзлийг баримтлах болсон байна. Яг Францын хувьсгал гарсан 1848 оны 12-р сарын 24-ний өдөрт хандах Токвилийн хандлага нь түүнийг гутрал, дарамтанд орсон явдлыг илтгэдэг. Токвиль нь парламентын гишүүний хувьд ардчилсан уур амьсгалд захирагдсан, хувийн ба улс төрийн эрх чөлөөнд хөтлөгдсөн сонирхолтой либерал-консерватор байсан...

Түүхийн детерминизм, тохиолдлын зүйлд үл итгэдэг социологич хүний хувьд А.де.Токвилийн хувьсгалыг авч үзсэн түүхэн дүрслэлийг дор авч үзье.

1848 оны Францын хувьсгалын үйл явцуудад өгсөн А.де.Токвилийн үзэл баримтлалууд нь “Дурсамж ” номонд нь тусгагдсан байдаг. Энэ бол түүний өөрийн үзэл санаандаа хөтлөгдөн бичсэн цорын ганц зохиол байсан. Тэрээр Үзэхдээ:

...”1830 оны 7-р сарын 30-ний өглөө Версалын гудамжинд Карл X-ийн тэргүүд дагалдан яг оршуулга шиг ар араасаа явж байхтай тааралдсан. Энэ үзэгдлийг хараад нулимс гоожив. Одоо (1848 он) миний сэтгэгдэл огт ондоо болсон ч илүү хүчтэй сэтгэгдэл төрж байна. Энэ бол сүүлийн 17 жилд миний нүдэн дээр болж өнгөрч буй хоёр дахь хувьсгал байлаа. Энэ хоёр хувьсгал хоёулаа надад гуниг авчирсан, гэвч сүүлчийн хувьсгалаас төрсөн сэтгэгдэл илүү гунигтай байсан. Би өөрийнхөө амьдралын хамгийн сайхан үеүдээ эрх чөлөөг олон дахин цэцэглэн мандаж буй нийгмийн орчинд өнгөрөөсөн. Энэ л нийгмийн орчинд би шүтлэг, зан суртахуун, хуулийн хүрээнд амьдарч, эрх чөлөөний тухай үзэл санаанд шургалж чадсан. Энэхүү эрх чөлөөний дур чадал намайг илбэдэж байна. Эрх чөлөө бол миний амьдралын дур хүсэл. Би эрх чөлөөгөө алдчихвал хэзээ ч тайтгарч чадахгүй гэдгээ мэдэрч байсан”... (*“Дурсамж” зохиол, 86-р хуудас*)

Хэдэн жилийн хойно А.де.Токвиль, 1848 оны хувьсгал бол “заяа муут” үйл явдал байсан юм гэдэгт хэзээнээс илүү итгэлтэй боллоо гэж бичиж байв.

Мэдээж, А.де.Токвиль энэ хувьсгалын шалтгааныг тайлбарлахыг оролдсон:

1848 оны Францын хувьсгал нь бусад үйл явдлуудын адил ерөнхий шалтгаанаар гарснаас гадна тохиолдлын зүйлүүдээр өдөөгдсөн юм гэжээ. Энэхүү хувьсгалыг төрүүлсэн тохиолдлын зүйлүүдийг дараах байдлаар тайлбарлажээ.

- эрх баригчдын байр суурь нь энэ өөрчлөлтүүдийг шаардсан бослогыг өдөөж өгсөн;
- угаасаа ямар ч хүчгүй болсон бослогыг дарсан явдал;
- засаглалын шугам тасарсан явдал, юу гэвэл нэг талаас хуучин сайдуудын гэнэтийн алга бололт, нөгөө талаас энэ засаглалыг шинэ сайдууд нь цаг хугацаанд нь барьж, сэргээж чадаагүй явдал;
- эдгээр шинэ сайдуудын сэтгэлийн хямрал ба алдаанууд, энэ шийдвэргүй байдлаа арилгахын тулд өөрсдийгөө хүчтэй, чадвартай гэдгээ баталж чадаагүй явдал;
- гол нь хаан Луи Филиппийн хүчгүйдлийг хэн ч урьдчилж хараагүй явдал байлаа.

Үүний зэрэгцээ А.де.Токвиль Францад нэгэн “сонирхолтой” үзэгдлийг илрүүлсэн. Энэ нь юу гэвэл, засгийн эрхэнд байгаа хүмүүсийг үзэн ядалт тойрон хурээлж байсан явдал юм.

Карл Маркс ба 1848 онд Францын хувьсгал **(Karl Marx / 1818-1883 / Germany)**

К.Маркс О.Конт, А.де.Токвиль хоёрыг бодвол 1848-1851 хоорондох түүхэн үеийг өөрөөр хүлээн авсан.

... К.Маркс хувьсгалт ухуулагч, сэтгүүлч байсныхаа хувьд энэ үйл явцад идэвхтэй оролцогч байлаа. Гэхдээ тэрээр урьд нь Францад очиж байсан ба Францын хувьсгалчдыг таньдаг, бодлогыг нь мэддэг байв. Иймээс К.Маркс Францын хувьсгалд идэвхтэй хөндлөнгийн гэрч байсан. К.Маркс өөрөө хувьсгалын хамтын шинжид итгэдэг байсан ба Францад болж буй хямрал түүнийг зайлшгүй хөндөж байна гэдэгт итгэж байв...

Түүний хоёр ном болох “1848-1851 онуудад болсон Франц дахь ангийн тэмцэл”, “Луи Бонапартын брюмерийн 18 он” зохиолоос нь Токвилийн “Дурсамж” зохиолд тусгагдсантай адил санааг олж үзэж болно.

1848 оны Францын хувьсгал, 1849 оны олон нийтийн үймээн. Энэ хоёрыг К.Маркс авч үзээд хоорондох эсрэг, тэсрэг байдлыг нь маш их гайхсан. К.Маркс 1848-1851 оны хоорондох үйл явдлууд бол зүгээр нэг улс төрийн үймээн бус, харин хувьсгалыг урьдчилан дохиолж байсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг. К.Маркс 1848 оны Францын хувьсгалыг нийгмийн зайлшгүй доргилт болж байна гэж тэмдэглэсэн байдаг. Тэрээр улс төрийн эрх чөлөөг хүндлэх явдал бол урьдах дэглэмийн мухар сүсэг юм гэж үзсэн.

К.Маркс, А.де.Токвиль 2 хоёулаа 1789 оны хувьсгалаас 1848 оны хувьсгал хүртэлх энэ шилжилтийг түүхэн логик мэтээр авч үздэг.

А.де.Токвилийн бодлоор, эдийн засгийн тэгш бус байдалтай тэмцэх нь түүний амьдарч байсан үед ямар ч амжилтанд хүрэхгүй байсан. Ер нь А.де.Токвиль тэгш бус байдлыг усташгүй зүйл гэж үзжэ. Учир нь энэ тэгш бус байдал нь нийгмийн мөнхийн салшгүй үзэгдэл гэж үзсэн.

Харин К.Маркс Үзэхдээ, нийгмийг шинэтгэн байгуулах замаар эдийн засгийн тэгш бус байдлыг багасгах буюу бүрмөсөн устгаж болно гэжээ.

Гэхдээ К.Маркс, А.де.Токвиль нарын аль аль нь нэг зүйл дээр анхаарлаа төвлөрүүлж байв. Тэд хувьсгалын хөгжлийн үечлэлийг тодорхойлох тал дээр адил байр суурьтай байсан юм. К.Маркс, Франц улс түүхэн маш бага хугацаанд орчин үеийн нийгэм дэх улс төрийн зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг туулж богино хугацаанд ихээхэн өөрчлөгдсөн байна гэж үзээд, хувьсгалын үечлэлийг дараах байдлаар хийв. Үүнд:

1. I Үечлэл. Энэ үед монархийг устгахын төлөө тэмцэж байв. Энэ үеийн түр засгийн бүрэлдхүүнд нь асар их нөлөө үзүүлэгч хэдхэн социалистууд багтаж байсан.
2. II Үечлэл. Энэ үе нь үүсгэн байгуулах хурлыг хуралдуулах явдалтай холбогдон гарч ирдэг. Энэ хуралд сонгогдсон ихэнх хүмүүс нь консерватив бүр монархи үзэлтэй хүмүүс байсан. Энэ хоёрын хооронд зөрчил гарсан. Энэхүү зөрчил нь 1848 оны 6 –р сарын үймээн болж хувирсан.
3. III Үечлэл. Энэ нь 1848 оны 12-р сар Луи Наполеоныг сонгосон Үеэс буюу К.Марксынхаар бол 1849 оны 5-р сар буюу үүсгэн байгуулах хурлын мөхлийн үеэс эхэлдэг.

А.де.Токвиль Үзэхдээ улс төрийн зөрчлийг нийгмийн маргаанаар тайлбарлах тал дээр тулгуурлан улс төрийн байгууллын автономит шинжийг буюу өвөрмөц шинжийг тайлбарлахыг оролдож байсан. Харин К.Маркс эсрэгээр улс төрийн үйл явдлууд нь ямар ч нөхцөл байдалд үүсч болох тухайд, мөн тэдгээрийн хоорондын харьцааг олохыг эрмэлзэж байв.

К.Марксын бодлоор жинхэнэ хувьсгал гэдэг бол “захиргаадалтын машин”-ыг эзэмших бус, харин булаан авахад оршино гэж Үзсэн.

К.Маркс онолчийнхоо хувьд улс төрийн бодлогыг түүний зөрчлүүдтэй нь хамт ангийн тэмцэлд аваачихыг оролдсон. К.Маркс зөрчилдөөний улс төрийн шалтгааныг янз бүрийн бүлгүүдийн хувьд төр нь автономит байдалтай байдаг гэдгийг хүлээн зөвшөөрч байсан. Энэхүү автономит байдал нь ямар хэмжээнд оршин байна тэр хэмжээгээр үүсэл тогтнол нь ангийн тэмцэлд хүргэдэггүй байна гэж Үзсэн.

О.Конт, А.де.Токвиль, К.Маркс нарын 1848-1851 оны Францын аугаа их хувьсгалын талаар авч үзсэнийг дурьдахын сацуу эдгээр сэтгэгчдийн үзэл баримтлал нь дараах гурван сургуулийн 5х үндсийг тавьсан болохыг авч үзье. Үүнд:

1. Эхний сургууль бол Франц дахь улс төр-социологийн сургууль

Үндэслэгчид нь Ш.Л.Монтескье (Sharli Lui Montesquie /1689-1755/ France), А.де.Токвиль нар юм. Энэ нь нилээн догматик шинжтэй социологичдын сургууль. Юу гэвэл, тэд ямар нэг бодлогыг л сонирхдог, нийгмийн үндэс, суурийг бүрэн гүйцэд үнэлж чаддаггүй. Тухайлбал, улс төрийн байгууллын автономит шинжийг тодорхойлоод, либерал үүднээс сэтгэдэг.

2. Хоёр бахь сурсууль бол Еонтйн сурсууль

Үндэслэгч нь *О.Конт*. энэ сургуулиас *Э.Дюрхейм* төрөн гарсан. Тэр үеийн Францын социологичид *О.Конт*ын энэ сургуульд хамаарагддаг. Энэ сургуулийнхан улс төрийн бодлого, эдийн засгийн асуудал зэргийн ач холбогдлыг төдийлөн гол болгон авч үздэггүй, харин нийгмийн асуудлыг чухалчлан судалдаг.

3. Гурав дахь сургууль бол Марксист сургууль

Үндэслэгч нь *К.Маркс*, *Ф.Энгельс* (*Fredrikh Engels /1820-1895/ Germany*). Энэ сургуулийг нийгэм, түүхийн тайзан дээр маи их амжилт олсон сургууль гэж үздэг юм.